

ШУТИС -ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хүнсний инженерчлэл хөтөлбөрийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи мэргэжлийн оюутнуудын онолын мэдлэгийг ур чадвар болгох, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилготой мэргэжлийн “Cook show” тэмцээн 2022-2023 оны хичээлийн жилд 24 дахь удаагаа зохион байгуулагдлаа. Энэхүү оюутнуудын мэргэжлийн тэмцээнд нийт 1-5 -р курсийн 48 оюутан 6 баг болон өрсөлдөж, амжилттай оролцлоо.

2022-2023 оны хичээлийн жилд “Cook show” тэмцээнийг С.Сэржмядаг зөвлөх багштай ХҮҮТ 4-р курсын оюутнууд 2023 оны 04-р сарын 16-нд зохион байгуулсан ба тэмцээний энэ жилийн онцлог нь оролцогч 6 багийг мэргэжлээрээ ажиллаж байгаа 6 төгсөгч технологийн зөвлөхөөр ажиллахаас гадна байр, номинацийн мөнгөн шагналыг ивээн тэтгэж оролцлоо. Мөн Монгол улсын Зөвлөх инженер, Гавьяат багш, Профессор Г.Энхтайван багш тусгай байрын шагналыг ивээн тэтгэж гардуулав.

Шүүгчээр багш нар болон “Crown” Зоогийн газрын Ерөнхий тогооч С.Эрдэнээ нар ажиллалаа.

Багуудаас тэмцээний нийлбэр оноогоор:

1– р байрын шилжин явах цом, мөнгөн шагналыг 4-р курсын оюутан С.Мөнх – Очир ахлагчтай “Бамбар” баг

2 -р байрын “Meal Plus”-ийн нэрэмжит шагналыг 4-р курсын оюутан Э.Анударь ахлагчтай “Огторгуй” баг

3 -р байрын Асем Вилла Рестораны технологич А.Тэмүүлэнгийн нэрэмжит шагналыг 4-р курсын оюутан О.Хаш-Эрдэнэ ахлагчтай “Симба” баг тус тус авч шалгарсан билээ.

Номинацийн шагналд :

Европ оройн хоолны иж бүрдэл хоол: “World wine” Рестораны технологич С.Анударийн нэрэмжит шагналыг 6 -р багийн А.Нандинлан, Г.Эрхэмбилэг нар,

Монгол хоол – махбодийн онцлогтой хоол: Төр засгийн ордны Зоогийн газрын Технологич Д.Болдхэтийн нэрэмжит шагналыг 4 -р багийн Э.Анударь, Б.Жаргалмаа

Ур чадвар: Технологич, Магистр Б.Мягмарнарангийн нэрэмжит шагналыг 4 -р багийн Б.Тэгшдүүрэн, М.Ган-Эрдэнэ нар,

Ширээ засалт – Хосуудын ширээ засалт: “Жансу Кореан Стейк хаус” Рестораны менежер М.Баянмөнхийн нэрэмжит шагналыг 6 -р багийн Б.Мөнгөнчимэг, Г.Билгүүн нар тус тус тэргүүллээ.

Нийт оролцогч :



1-р байр: С.Мөнх – Очир /4-р курс/ ахлагчтай “Бамбар” баг



2-р байр: Э.Анударь / 4-р курс / ахлагчтай “Огторгуй” баг



3-р байр: О.Хаш-Эрдэнэ /4-р курс/ ахлагчтай “Симба” баг



Номинацын шагнал:

“Европ – Оройн хоолны иж бүрдэл хийх:

3-р курсын оюутан А.Надинлан,
1-р курсын оюутан Г.Эрхэмбилэг



Монгол хоол- Махбодийн онцлогтой:

4-р курсын оюутан Э.Анударь,
1-р курсын оюутан Б.Жаргалмаа

“Ур чадвар”-Өгөгдсөн материалаар хоол

4-р курсын оюутан Б.Тэгшдүүрэн
2-р курсын оюутан М.Ган-Эрдэнэ



“Хосуудын ” Ширээ засалт
2-р курсын оюутан Б.Мөнгөнчимэг
1-р курсын оюутан Г.Билгүүн

Тэмцээний үеийн үйл явц:



Тэмцээний үеийн бүтээлүүд:

